

Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ မူ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません

カードに書かれた字を全部使って、一つの漢字にしましょう。

組み合わせる時に、少しは変わるようにせよ。

こくごのもり

指導・元世田谷区立 小学校教諭 高橋 裕子
イラスト・奈良 恵

こくごのもり

答えはP22にあります。

Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2020 оны 4 дүгээр сар, Хаврын дугаар

Япон хэл суралцах ба хэлний шалгалт өгөх

Ур чадварын дадлага, сургалтын хамгийн гол зорилго нь аж үйлдвэрийн салбарын ур чадвар, техник, мэдлэгийг эзэмшихэд байгаа билээ. Хэдий тийм боловч, Япон хэлээр ярьж чаддаг болвол, эргэн тойрныхоо Япон хүмүүстэй харилцахад хялбар болж, ур чадварын дадлагын ойлгоцын түвшин ч гүнзгийрэн, гологдол бараа үүсэх болон хөдөлмөрийн осол гарах, өдөр тутмын амьдралд ч осол гарахаас сэргийлэхэд эерэгээр нөлөөлнө. Та бүхний Япон хэлний чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор, JITCO нь жил бүр “Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-ыг зохион байгуулдаг. Суралцсан Япон хэлний чадвараа ашиглах зорилгоор ч гэсэн, та бүхэн тус зохион бичлэгийн уралдаанд идэвхтэй оролцож, өөрийгөө сорьж үзээрэй. (Дараах мэдээлэлтэй мөн танилцана уу.)

Та бүхний дунд Япон хэлний чадвараа ашиглах талбар болгон, Япон хэлний шалгалтын талаар сонирхож байгаа хүмүүс ч олон байгаа боловч уу. Та бүхний “сэнпай нар” буюу Япон дахь дадлага, сургалтанд хамрагдсан хүмүүсээс нутаг буцсаныхаа дараа “Суралцсан Япон хэл нь өндрөөр үнэлэгдэж, томилж явуулсан компанидаа тушаал дэвшсэн.”, “Япон хэлний чадвараа ашиглан, Японы компанид ажилд орсон.”, “Өөрөө компани байгуулж, Японы компанитай бизнес хийж эхэлсэн.” гэх мэт мэдээллүүд хүргэгдэх нь байдаг ба ингэж Япон хэлний чадвараа ажил мэргэжлийн карьертэйгээ шууд холбохын тулд, хэлний шалгалт өгөх зэрэг замаар объектив үнэлгээ авах шаардлагатай юм.

Гадаад иргэдийн Япон хэлний чадварыг шалгаж, үнэлэн магадалдаг хэд хэдэн төрлийн шалгалтууд байдаг бөгөөд энэ удаа хамгийн олон хүн шалгалт өгдөг **Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT)**-ын талаар танилцуулъя. JLPT нь хамгийн амархан түвшин болох N5-аас хамгийн хүнд түвшин болох N1 хүртэл нийт 5 шатлалтайгаар түвшин нь хуваагдсан байдаг ба Ур чадварын дадлагажигч нар N4 юм уу N3-ыг өгөх тохиолдол их байдаг бололтой. Түвшин тус бүрийн даалгаврын жишээ нь цахим хуудсанд (<http://www.jlpt.jp/>) тавигдсан байгаа бөгөөд туршилтын журмаар даалгаврыг нь гүйцэтгэж үзэхийг санал болгож байна. (Мөн шалгалт өгөх өргөдлийг зөвхөн интернетээр хүлээн авдаг.) Тус шалгалт нь Японы 47 мужууд болон гадаадад жилд 2 удаа (7 дугаар сар, 12 дугаар сар) зохион байгуулагддаг ба 7 дугаар сарын шалгалтын өргөдөл хүлээн авах цаад хугацаа нь 4 дүгээр сарын сүүлч юм.

Япон хэлийг суралцахад тасралтгүй давтах шаардлагатай бөгөөд шалгалтанд ч гэсэн түр хугацаанд давтаад тэнцэхэд хэцүү. Шалгалт өгөгчдөд зориулсан даалгаврын цуглуулгыг ч гэсэн зүгээр л даалгавар гүйцэтгэж үзээд орхилгүйгээр, олон удаа давтан суралцахуйцаар, гүйцэтгэлээ өөр цаасан дээр бичиж үзэх, урт өгүүлбэр уншаад ойлгох чадвар шалгах даалгаврыг чанга дуугаар уншиж үзэх, сонсоод ойлгох чадвар шалгах даалгаврын бичлэгийг нь олон удаа давтан сонсож үзэх гэх мэтээр давтаарай.

Шалгалт өгөхөөр товлож байгаа хүмүүс өөрийнхөө харъяалагдаж байгаа байгууллага юм уу компанийнхаа хүнээс шалгалт өгөх талаараа зөвлөгөө авахыг хүссэн ч болох боловч уу. Мөн, Япон хэлний удирдагч багш болон ажлын газрынхаа ахмад ажилтандаа ч гэсэн Япон хэл суралцах талаар зөвлөгөө авах хүсэлтэй байгаа талаараа ярьж үзээрэй. Япон хэл суралцах нь хүнд хэцүү байж магадгүй хэдий ч та бүхэн идэвхтэйгээр суралцана гэж найдаж байна.

☆ Бүтээл хүлээн авч байна ☆

Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн 28 дахь удаагийн уралдааны тухай мэдээлэл

4 дүгээр сарын 1-ний өдрөөс “Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-д оролцох бүтээлийг хүлээн авч эхэллээ.

Бүтээл ирүүлэх цаад хугацаа нь, 5 дугаар сарын 11-ны өдөр (Даваа).

Уралдаанд оролцох тухай дэлгэрэнгүй мэдээллийн талаар, “JITCO-гийн цахим хуудас” (<https://www.jitco.or.jp/>), JITCO Япон хэлний сурах бичгийн хироба (Талбай)” (<https://hiroba.jitco.or.jp/>)-гийн 2020 оны 2 дугаар сарын 3-ний өдрийн “Мэдээлэл”-д нийтэлсэн байгаатай танилцана уу.

Жил бүр маш олон бүтээл ирүүлдэг бөгөөд та бүхэн бас идэвхтэй оролцоорой.

Унадаг дугуйны осол ба Японд баримталдаг дүрэм

Японд өдөр тутамд унадаг дугуй хэрэглэдэг Ур чадварын дадлагажигч, суралцагч олон байдгийн зэрэгцээгээр, унадаг дугуй унаж явж байгаад машинд мөргүүлэн, хохирогч болсон осол болон унадаг дугуйгаар хүн мөргөөд, хохирол учруулагч болсон ослын аль аль нь гарч байна. Ур чадварын дадлагажигч, суралцагчийн холбогдсон зам тээврийн ослын шалтгаанд Японы замын хөдөлгөөний дүрэмд дасаагүй байхтай холбоотой шалтгаан их байдаг бололтой. Хууль зүйн яамны цахим хуудсан дахь "Гадаад иргэдийн Японд оршин суухад нь дэмжлэг үзүүлэх портал сайт"-ад тавигдсан Японд оршин суугч гадаад иргэдэд зориулсан "Оршин суух, хөдөлмөр эрхлэх хөтөч"-д унадаг дугуйны осол гарах магадлал өндөртэй газрын нэг болох замын уулзвар дээр унадаг дугуй унах дүрмийн талаар бичигдсэн байгааг танилцуулъя.

Замын уулзвараар зорчих дүрэм

Баруун тийшээ эргэхэд

[Гэрлэн дохиотой газар] Ногоон гэрлээр, замын уулзварын зүүн захынх нь дагуу явах ба замын цаад булан хүртэл чигээрээ урагшаа явж, түр зогсоод, чиглэлээ өөрчилнө. Өөдөөс харсан гэрлэн дохионы ногоон гэрэл ассаны дараа, өмнөх, хойд, баруун, зүүн талынхаа аюулгүй байдлыг магадалж байж, урагшаа чигээрээ явна.

[Гэрлэн дохиогүй газар] Хойд талынхаа аюулгүй байдлыг магадалж, замын зүүн захынх нь дагуу явах ба замын цаад булан хүртэл чигээрээ урагшаа явж, аюулгүй байдлыг магадалсны дараа, баруун тийшээ эргэн, урагшаа чигээрээ явна.

Зүүн тийшээ эргэхэд

Зүүн тийшээ эргэснийхээ дараа, замын гарцаар гарч буй хүмүүсийн замд саад бүү болоорой.

"Түр зогс" тэмдэглэгээтэй газар

"Түр зогс" тэмдэглэгээтэй газарт, заавал түр зогсож, баруун, зүүн талынхаа аюулгүй байдлыг магадалсны дараа урагшаа явна. Харагдах байдал муу замын уулзвараар зорчихдоо ч, өргөн замаар зам хөндлөн гарахдаа ч, түр зогсож, аюулгүй байдлыг магадлаарай.

Унадаг дугуйнд зориулсан зам хөндлөн гарах бүстэй газар

Замын уулзвар болон түүний ойролцоо унадаг дугуйнд зориулсан зам хөндлөн гарах бүстэй бол, тухайн бүсээр гарна.

(Цагаачлалын үйлчилгээний агентлагаас боловсруулсан "Оршин суух, хөдөлмөр эрхлэх хөтөч"-өөс)

Гадаад иргэдийн Японд оршин суухад нь дэмжлэг үзүүлэх портал сайт

(Япон хэл)	http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri10_00055.html
(Хялбар Япон хэл)	http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri10_00062.html
(Англи хэл)	http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/m_nyuukokukanri10_00006.html
(Вьетнам хэл)	http://www.moj.go.jp/content/001304607.pdf

Мөн, JITCO нь Ур чадварын дадлагажигч нарт зориулан, Япон дахь амьдралдаа аль болох хурдан дасч, ая тухтай амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор, замын хөдөлгөөний дүрмээс авахуулаад төрөл бүрийн мэдээллийг хамарсан "Японд амьдран суухад туслах хөтөч" нэртэй номыг хэвлэн гаргаж байна. Зөвхөн замын хөдөлгөөний тухай бус, Японы нийгмийн янз бүрийн дүрмийг мэдэж авах нь та бүхний Япон дахь амьдралд сэтгэлийн амар амгалан байдлыг авчирч, аюулгүй байдлыг тань хангах болно. Тус ном нь Япон хэлний хамт гадаад хэлний орчуулгыг нь зэрэгцүүлэн нийтлэх хэлбэрээр Вьетнам хэл, Хятад хэл, Филиппин хэл, Индонези хэл, Тайланд хэл, Камбодж хэл, Мьянмар хэл, Монгол хэл, Англи хэл, Лаос хэл, Шинхала хэл, Непал хэлний хувилбарууд тус тус байдаг ба JITCO-гийн сурах бичгийн төвд худалдаалж байна.



Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Цүнхэндээ нэгийг —



Шүхэр авч гараагүйдээ харамссан Маруй сан байв.

Нэгэн судалгааны дүнд, нэг хүнд ноогдох шүхэрний эзэмшлийн тоогоороо Япон дэлхийд 1-р байранд орсон байна. Мөн гэнэт бороо ороход бэлтгэлтэй байхын тулд, гадагшаа гарахдаа эвхдэг шүхэр цүнхэндээ хийж авч явдаг хүн ч олон байдаг. Маш хөнгөн жинтэй, борооноос хамгаалах, нарнаас хамгаалахад аль алинд нь хэрэглэдэг зориулалтын, салхинд тэсвэртэй гэх мэтээр функцийн нэмэлт онцлогтой эвхдэг шүхрүүд ч олширч байна.

◆こくごこたえ

⑦ 親 ⑤ 船 ③ 校 ① 岩
⑥ 語 ④ 寺 ② 森

紙の上にはばらばらに置かれた字。どれも一つの字です。それらをみんな集めて、新しい一字にします。一つの字になる時に、どこかが微妙に変わるものもあるでしょう。漢字は意味を持つ字ですが、別の文字と組み合わせると、新たな意味を持つことにも気づけるといいですね。

Các bạn hãy nhìn những chữ riêng rẽ trong những hình vuông dưới đây. Mỗi chữ trong ô đều là 1 chữ riêng biệt, có nghĩa. Nhưng nếu tập hợp những chữ riêng lẻ đó lại thì chúng ta sẽ có 1 chữ mới. Khi kết hợp trong một chữ, cách viết mỗi chữ có ít nhiều thay đổi. Mỗi từ kanji (chữ Hán) đều có nghĩa nhưng nếu kết hợp với nhau thì chúng sẽ trở thành 1 từ mới. Hy vọng các bạn nhận ra được điều đó.

纸上七零八落地排列着一些文字。每一张都是一个文字。把这些集中在一起组成一个新的文字。变成一个字的时候，在某些地方会有微妙的变化。汉字是表意文字，和别的文字组合在一起又会产生新的意思，希望大家能注意到。

Ang hiwa-hiwalay na nakasulat sa papel ay pare-parehong isang character lamang. Kolektahin ang mga ito at gumawa ng bagong character. Ang ilang mga character ay maaaring magbago nang kaunti kapag sila ay naging isang character.
Ang Kanji ay isang character na may kahulugan, ngunit kapag pinagsama sa ibang character, mapansin ninyo sana na mayroon itong bagong kahulugan.

Huruf yang ditaruh secara acak di atas kertas. Semuanya adalah sebuah huruf. Kumpulkan semuanya dan jadikan menjadi sebuah huruf baru. Pada waktu menjadi sebuah huruf, terkadang ada yang mengalami sedikit perubahan. Semoga dapat menyadari bahwa kanji adalah huruf yang memiliki arti, tetapi jika digabungkan dengan huruf lain maka akan memiliki sebuah arti baru.

ตัวอักษรที่วางกระจายโดยนกระดาษทุกตัวล้วนแล้วแต่เป็นอักษรตัวเดียว เมื่อเอาทุกตัวมารวมกันเป็นอักษรใหม่หนึ่งตัวก็จะมีตรงไหนสักที่ที่เปลี่ยนแปลงไปเล็กน้อย หากสังเกตก็จะเห็นว่า เมื่อนำอักษรคันจิซึ่งมีความหมายในตัวไปรวมเข้ากับอักษรตัวอื่นก็จะมีความหมายใหม่ขึ้นมา

តួអក្សរត្រូវបានដាក់ចែបលំដាប់នៅលើក្រដាស។ មួយណាក៏ជាអក្សរមួយតួដែរ។ សូមប្រមូលអក្សរគ្រប់តួមកផ្គុំគ្នា ដើម្បីបង្កើតអក្សរថ្មីមួយ។ ពេលក្លាយជាតួអក្សរថ្មី កន្លែងខ្លះមានការប្រែប្រួលបន្តិចបន្តួច។ អក្សរកាន់ជី គឺជាអក្សរដែលមានអត្ថន័យ ប៉ុន្តែវាជាការប្រសើរណាស់ដែលអ្នកអាចកត់សំគាល់ថាវាមានអត្ថន័យថ្មីមួយទៀត នៅពេលផ្សំតួអក្សរកាន់ជីផ្សេងៗចូលគ្នា។

တရုတ်ပေါ်မှာ သီးခြားစီ ရှိနေတဲ့ စာလုံးတွေ၊ အားလုံး စာလုံးတစ်လုံးတည်း ဖြစ်ပါတယ်။ ဒါတွေကို စုစည်းပြီး စာလုံးသစ်ဖွဲ့ပါ။ တစ်လုံးတည်း ဖြစ်လာချိန်မှာ မသိသာ ပြောင်းလဲသွားတာလည်း ရှိပါလိမ့်မယ်။ ခန်းဂျီးဟာ အဓိပ္ပာယ်ပါဝင်တဲ့ စာလုံးဖြစ်ပေမဲ့ တခြားစာလုံးနဲ့ ပေါင်းစပ်တဲ့အခါ အဓိပ္ပာယ်သစ်ကို ဆောင်တယ်ဆိုတာကိုလည်း သတိပြုမိနိုင်ပါစေ။

Цаасан дээр дэс дараалалгүйгээр тавигдсан үсэгнүүд. Бүгдээрээ нэг нэг үсэг. Эдгээрийг бүгдийг нь цуглуулаад, нэг шинэ үсэг бүтээнэ. Нэг үсэг болох үедээ аль нэг хэсэг нь ялимгүй өөрчлөгдөх үсэг ч гарах байх. Ханз нь утга илэрхийлдэг үсэг бөгөөд өөр үсэгтэй нийлүүлэхээр, өөр утга илэрхийлдэг болохыг анзаарч чадвал сайн байна.

A number of kanji characters are randomly shown on each piece of paper. They are each an independent character. Put these characters together and create a new character. Note that some may change slightly when they form the new character. You will probably realize that while each kanji character has its own meaning, combining them with different characters allows them to express a new meaning.

技能実習生・研修生向母国語情報誌 発行 公益財団法人 国際人材協力機構 (JITCO)
技能実習生の友 総務部広報室
2020年4月 春季号 〒108-0023
2020年4月1日発行 東京都港区芝浦 2-11-5
五十嵐ビルディング
電話 03-4306-1166 (ダイヤルイン)
JITCO ホームページ https://www.jitco.or.jp/